

Солонгос 「Гэр бүлийн сарыг угтан」 олон улсын оюутанд зориулсан Солонгос соёлын туршлага

□ Туршлагын агуулга

1. Улаан лиштэй үзэг хийх : 5 сарыг угтан хүүхдийн өдөр, эцэг эхийн өдөр, багш нарын өдрийн утгыг ойлгуулан, туршлагаар дамжуулан эцэг эхийн өдрийн утгыг эргэцүүлэн бодох



2. Улаан шуудангийн хайрцаг : Өөрийн биеээр хийсэн цэцэгтэй үзэг болон захиагаар оюутны талархсан сэтгэлээ дамжуулахыг хүссэн оронд нь дамжуулж өгнө

- Улаан шуудангийн хайрцаг байрлуулсан газар : 5 сарын 14(Баасан) үдээс хойш 3 цаг хүртэл дэмжигчдийн өрөөний үүд
- Гадаад шуудан 3 хүн, дотоодын шуудан 10 хүнг сугалаагаар сонгогдсон оюутнуудын хүрээнд явуулж өгнө
- Сургууль дотор хүргүүлэх нь өргөдөл гаргасан бүх хүмүүсийг боломжоор хангана

3. Хамрах хүрээ : Манай сургуульд сурж буй оюутан

4. Хэрэгжих хугацаа : 2021. 05. 10(Даваа) ~ 05. 14(Баасан) доорх өдрүүдээс 1-г сонгох

5/10	5/11	5/12	5/13	5/14
Үдээс хойш 3 цаг	Үдээс хойш 2 цаг	Үдээс өмнө 10 цаг	Үдээс хойш 2 цаг	Үдээс өмнө 10 цаг

5. Хүний тоо : 2021.05.06. am9:00 서포터즈실 Эхний 60 хүн

- **Хүүхдийн өдөр** : Хүүхдүүдийн хувь хүнийг хүндэтгэн, аз жаргалыг сурталчлах зорилготой ойн өдөр. Жил бүрийн 5-р сарын 5-ны өдөр юм. 1922 онд Бен Жон Хван тэргүүтэй Чонодугюү Сөүлийн салбар хөвгүүдийн холбооноос “Хүүхдийн өдөр”-ийг тунхаглан, дараа жил нь 5-р сарын 1-ний өдрийг “Хүүхдийн өдөр” болгон шийвдэрлэсэн нь эхлэл байв. Японы колоницлолын төгсгөлд үүнийг зогсоосон боловч чөлөөлөгдсөний дараа 1946 оны ойн баярт дахин тэмдэглэх болсон тул 5-р сарын 5 болгон өөрчилжээ.

- **Эцэг эхийн өдөр** : Ач ивээлд талархан, Уламжлалт нийгэмд үр хүүхдийн ариун зан чанарыг төлөвшүүлэх хууль ёсны ойн баяр. 1956 оны 5 сарын 8-ны өдрөөс эхлэн тэмдэглэж ирсэн 'Ээжүүдийн өдөр' арга хэмжээнээс эхлэн, 1973 оны 3 сар <Олон янзын ойн өдөр тэмдэглэх журам> -аар хууль ёсны ойн өдрийг ' Эцэг эхийн өдөр' болгон өргөжүүлэн батлав. Энэ өдөр ээжээр зогсохгүй аавыг оролцуулан эцэг эх болон ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх сэтгэлийг агуулсан удам угсааны ариун журмыг онцлон тэмдэглэсэн ой болгон өргөжүүлэв.

- **Багш нарын өдөр** : Багш нарын өдөр нь 1958 оны 5 сар Залуучуудын Улаан загалмайн нийгэмлэгийн гишүүн Чунченг-Ду мужийн Канггён Охидын ахлах сургуулийн сурагчид одоо ажиллаж байгаа багш, тэтгэвэрт гарсан багш, өвчтэй багш нар дээр сайн дураараа очиж уулзахаас эхэлсэн юм. Үүнийг утга учиртай гэж үзэн Залуучуудын Улаан загалмайн нийгэмлэгийн Чуннам зөвлөл 1963 оны 9 сарын 21-ний өдрийг Чунчхон-Намдо мужийн "Ачтан багшийн өдөр" болгон тэмдэглэж, талархлын арга хэмжээ зохион байгуулав. 1964 оноос эхлэн 'Багш нарын өдөр' гэж нэрлэж эхэлсэн бөгөөд энэ өдрийг мөн 5 сарын 26 болгон өөрчилсөн.

1965 оноос манай үндэстний хамгийн агуу багш Сежон хааны төрсөн өдөр буюу 5-р сарын 15-ны өдрөөр болгон өөрчилсөн. Нэмж дурдахад 1966 оноос хойш Солонгосын Улаан Загалмайн нийгэмлэг багш нарын өдрийн дууг өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж, уг арга хэмжээний хамт тус дууг улс даяар тараажээ. Гэсэн хэдий ч 1970-аад онд Пак Чон Хигийн дэглэмийн дагуу 1973 оны 3 сард бүх боловсролтой холбогдолтой баяр тэмдэглэх арга хэмжээг "Үндэсний боловсролын дүрмийн тунхаглал" -д тусгаж, "Багш нарын өдөр"-ийг 1981 он хүртэл хоригложээ. Үүний дараа 1982 оны 5-р сард батлагдсан <Олон янзын ойн өдөр тэмдэглэх журам>-ын дагуу 9 жилийн дараа сэргээж, хууль ёсны ойн өдөр болгон тэмдэглэсээр өнөөг хүртэл мөрдөгдөж байна.